



**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/125

Улаанбаатар хот

Төлбөрийн хэмжээг батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 155 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөлийн дүрэм”-ийн 3.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын багц цагийн болон мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтын төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /У.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

Барилга, хот байгуулалтын яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны
07 дугаар сарын 05 -ны өдрийн
А/125 дугаар тушаалын хавсралт



**БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
СУРГАЛТЫН БАГЦ ЦАГИЙН БОЛОН МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ
ГОРИЛОХ, СУНГАХ ШАЛГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

№	Үйлчилгээ	Хэмжээ	Үнэ, тариф /төгрөг/
1	Мэргэшсэн зэрэг горилох, сунгах сургалтын багц цагийн үнэ	1 багц цаг	45,000.00
2	Зөвлөх болон тэргүүлэх зэрэг горилох, сунгах сургалтын багц цагийн үнэ	1 багц цаг	73,000.00
3	Мэргэшлийн зэрэг горилох, сунгах шалгалтын төлбөр	1 удаагийн	80,000.00